



“ТӨРИЙН БАНК” ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.02.26 № 1/229
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай банкаас зарласан “Даатгалын үйлчилгээ үзүүлэх” тухай ТБ/201808431 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Хаан даатгал” ХХК-аас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 4.2.а.13-т “Санхүүгийн зохицуулах хорооноос 2017, 2018 онуудад аливаа шийтгэл, арга хэмжээ авагдаагүй байх” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Энэ хуулийн 14.1-д заасан нөхцөл байдал үүссэнийг тендерт оролцогч Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын дараахь баримт бичгээр нотолж болно.” гэж, 14.3.1-т “Шүүхийн шийдвэр болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг.” гэж, 14.4-т “Энэ хуулийн 14.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх шаардлагатай баримт бичгийг тендерийн баримт бичигт тусгайлан заана.” гэж тус тус заасан байдаг.

Иймээс тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 4.2.а.13 дахь заалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.

Мөн Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага **хуульд зааснаас бусад тохиолдолд** дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэж, 13.2.7-д “Аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн.” үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасныг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд тус тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

Хувийг: “Хаан даатгал” ХХК -д

ДАРГА

Б.ЛХАГВА

000078